



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 108

Мандалговь

Үндсэн хөрөнгийг данснаас хасах,  
эргэлтийн хөрөнгөд бүртгэх худалдан борлуулах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.4.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 1/1362 албан тоот, Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 06-ны 49 дүгээр тогтоол, Сайнцагаан сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын шийдвэр, Говийн ирээдүй цогцолбор сургуулийн өмч хамгаалал зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хурлын шийдвэр, аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны 6/1403 албан тоот, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2,047,758,000 (хоёр тэрбум дөчин долоон сая долоон зуун тавин найман мянга) төгрөгийн балансын үнэтэй, 243,886,671.03 (хоёр зуун дөчин гурван сая найман зуун наян зургаан мянга зургаан зуун далан нэгэн төгрөг гурван мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хичээлийн А байрын (буулгасан) барилгыг данснаас хасах, гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Говийн ирээдүй цогцолбор сургуулийн захирал (Г.Мягмарсүрэн) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1. Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хоёрдугаар хавсралтын дагуу эргэлтийн хөрөнгөд бүртгэх, илүү гарсан хуучин материалыг худалдах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 11 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэргүйгээр үл хөдлөх хөрөнгийг дур мэдэн буулгасан буруутай этгээдэд хариуцлага тооцохыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д даалгасугай.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын  
26... өдрийн Хуралын тогтоолын Хэвсрэлт



Говийн ирээдүй цогцолбор сургуулийн актлах барилгын мэдээлэл

Д/д	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтад орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжих нэгж	Биет хэмжээ					
1	Хичээлийн "А" байр	Хичээлийн байр	хүүхэд	960	1965.09.01	60	2,047,758,000	1,803,871,328.97	243,886,671.03
<b>Дүн</b>									
<b>243,886,671.03</b>									
<b>/хоёр зуун дөчин гурван сая найман зуун наян зургаан мянга зургаан зуун далан нэгэн төгрөг гурван мөнгө/</b>									

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын  
06-ний өдрийн №2 тогтоолын 2-р хавсралт



Говийн ирээдүй цогцолбор сургуулийн хичээлийн А байрны  
барилгын акталснаас гарсан эргэлтийн хөрөнгөд бүртгэх,  
худалдан борлуулах материалын жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмж их нэгж	Тоо	Эргэлтийн хөрөнгөд бүртгэх			Худалдан борлуулах		
				То о	үнэ	Нийт	Тоо	Үнэ	Нийт
1	Цонх	ш	64	16	80000	1280000	48	80000	3840000
2	Хаалга	ш	37	12	45000	540000	25	45000	1125000
3	Бүргэд хаалга	ш	2	1	50000	50000	1	50000	50000
4	Шалны банз	ш	1515	-	-	-	1515	2000	3030000
5	Палк мод	ш	49				49	20000	980000
6	Хучилтын банз	ш	785				785	5000	3925000
7	Прүс мод	ш	158				158	1000	158000
8	Түлшний мод	порте р	5				5	50000	250000
9	Цэвэр усны шугам	м	152				152	10000	1520000
10	Халаалтын радиатор 15 секцтэй	ш	1				1	8500	127500
11	Халаалтын радиатор 14 секцтэй	ш	2				2	8500	238000
12	Халаалтын радиатор 13 секцтэй	ш	3				3	8500	331500

13	Халаалтын радиатор 12 секцтэй	ш	6				6	8500	612000	
14	Халаалтын радиатор 11 секцтэй	ш	13				13	8500	1215500	
15	Халаалтын радиатор 10 секцтэй	ш	31				31	8500	2635000	
16	Халаалтын радиатор 9 секцтэй	ш	23				23	8500	1759500	
17	Халаалтын радиатор 8 секцтэй	ш	13				13	8500	884000	
18	Халаалтын радиатор 7 секцтэй	ш	7				7	8500	416500	
19	Халаалтын радиатор 6 секцтэй	ш	6				6	8500	306000	
20	Халаалтын радиатор 5 секцтэй	ш	8				8	8500	340000	
21	Халаалтын радиатор 4 секцтэй	ш	3				3	8500	102000	
22	Халаалтын радиатор 3 секцтэй	ш	1				1	8500	25500	
23	Халаалтын радиатор 2 секцтэй	ш	1				1	8500	17000	
	Нийт дүн								<b>1870000</b> /нэг сая найман зуун далан мянга/	<b>23888000</b> /хорин гурван сая найман зуун наян найман мянга/